

“Шүүх эрх мэдлийн хүрээнд шинэтгэлийг  
гүнзгийрүүлэх хөтөлбөрийн тухай”

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2010 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Шүүх эрх мэдлийн хүрээнд шинэтгэлийг гүнзгийрүүлэх хөтөлбөрийн тухай” Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газрын дарга Д.Дорлигжавын илтгэлийг хэлэлцээд, илтгэлд дурдсан шүүх эрх мэдлийн байгууллагуудын үйл ажиллагааны шударга байдал, чанар, үр нөлөөг сайжруулах шаардлагатай гэсэн дүгнэлтийг үндэслэн уг хөтөлбөрийг дэмжиж, түүнд тусгагдсан санал, тулгамдсан асуудлыг яаралтай шийдвэрлэхийн чухлыг тэмдэглэн ЗӨВЛӨМЖ болгох нь:

Нэг. Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газарт:

1. “Шүүх эрх мэдлийн хүрээнд шинэтгэлийг гүнзгийрүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх үүднээс холбогдох хуулиудыг санаачлан боловсруулах,

2. Зорилтот хөтөлбөрийн хүрээнд шүүх эрх мэдлийн байгууллагууд дахь хариуцлагын тогтолцоог үр нөлөөтэй болгож, түүний шалгуурыг шинэчилж хэрэгжүүлэх асуудалд онцгойлон анхаарал хандуулж ажиллах.

Хоёр. Монгол Улсын Улсын Их Хуралд:

Хуулиудыг нэн даруй хэлэлцэн батлах арга хэмжээ авах.

Гурав. Монгол Улсын Засгийн газарт:

Шинээр батлагдах хуулиудыг хэрэгжүүлэхэд шаардагдах зохион байгуулалт, төсөв санхүүгийн болон хөтөлбөрт тусгагдсан бусад арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх.